



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Спортын тэмцээн зохион байгуулах  
тухай

Монгол улсын Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 11 дүгээр сарын 02,03-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Амгалан дулааны станц ТӨХК-ийн 2023 оны сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээний зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

3. Тэмцээний зардлыг батлагдсан төсвийн дагуу тооцон олгохыг Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга бөгөөд Ерөнхий нягтлан бодогч (Ө.Удвал)-д зөвшөөрсүгэй.

4. 2023 оны 11 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдэд ажлын байрны дэг журамд хяналт тавьж, үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг ханган ажиллахыг цех, хэлтсийн дарга, ИТА нарт, Спортын уралдаан тэмцээнийг батлагдсан төсвийн дагуу зохион байгуулахыг Спорт, урлаг хариуцсан зохион байгуулагч Ш.Отгонбаярмаад, тэмцээн зохион байгуулагдах өдрүүдийн сахилга, дэг журамд хяналт тавьж гарсан зөрчлийг шуурхай шийдвэрлүүлж ажиллахыг Хуулийн мэргэжилтэн (Г.Саруул)-д тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтсийн дарга (Б.Ган-Очир), Хяналтын хэлтсийн дарга (Ц.Мандахсайхан) нарт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МӨНХӨӨ

• 132301827